



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/30

Өргөн

Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сумын аварга малчин” шалгаруулах журмыг нэгдүгээр хавсралтаар, “Сумын аварга саальчин” шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Журмын дагуу хүлээн авч Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хөдөө аж ахуйн тасагт үүрэг болгосугай.

3.Шагналд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), нягтлан бодогч (Э.Цолмонзаяа) нарт зөвшөөрсүгэй.


4.Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны А/88 дугаар захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Пүрэвдаш)-д даалгасугай.

ДАРГА

В.БАТЖАРГАЛ

642401388



СУМЫН АВАРГА МАЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлэх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Сумын аварга малчин"-аар шалгаруулна.

1.3. "Сумын аварга малчин"-аар шалгаруулах асуудлыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шалгуур үзүүлэлт хангасан малчдын материалыг Хөдөө аж ахуйн тасаг хүлээн авч, Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Хоёр. "Сумын аварга малчин" шалгаруулахад тавигдах шалгуур үзүүлэлт.

2.1. Мал сүргээ 3-аас дээш төрлөөр өсгөж, оны хээлтэгч тутмаас 100% төл бойжуулсан байна. Нийт мал сүргийн 20% нь бод, 35% нь хонь байна.

2.2. Сүрэгт эзлэх хээлтэгч мал нь бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувьд хүрсэн эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх.

2.3. Малыг индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эхнэр, нөхөр сүүлийн 3 жил эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх.

2.4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний Календарчилсан төлөвлөгөөнд мал сүргээ бүрэн хамруулж, Мал эмнэлгийн үйлчилгээний лавлагааг нэгдсэн системээс татан авч мал эмнэлгийн улсын байцаагчаар баталгаажуулах.

2.5. Сүүлийн 3 жил өвөлжөө, хаваржаа, халдваргүйжүүлэлтэд хамруулсан байх.

2.6. Хоршоо бүлгийн зохион байгуулалтад нэгдэн хамтран ажилладаг байх.

2.7. Тухайн бүс нутагт өсгөн үржүүлэхээр баталгаажсан үүлдэр, омог, хэвшлийн малаар малын чанараа сайжруулсан байх.

2.8. Говь, цөлийн бүсэд тогтоосон нормын дагуу хонин толгойд шилжүүлсэнээр 5 кг-аар тооцож, хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх.

2.9. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод болон малын тэжээлийн ургамал тариалсан байх БОУБ-ийн тодорхойлолт.

2.10. Малын тоо толгойг тооцохдоо бусдаас худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан малыг оруулан тооцохгүй.

2.11. Тухайн малчин нь бэлчээр нутгийн маргаангүй, өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, гэрийн хашаа, малын хашаа, өвс тэжээлийн хашаа, 00, уст цэгтэй түүнийгээ засч тохижуулдаг байх.

2.12. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг хувиарийн дагуу ашиглах, отор хийх, сэлгэх, өнжөөх, зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх.

2.13. Байгалийн эрсдэлийг даван туулахад ашиглах эрсдэлийн сан, хуримтлал бий болгосон байх. Сангийн доод хэмжээ 500,000 төгрөг байна. (Банкны тодорхойлолт)

2.14. Мал сүргээ бэлчээрийн даацад тохируулан эдийн засгийн эргэлтэд оруулан, өрхийн орлогоо нэмэгдүүлж, мал аж ахуйн материаллаг баазаа бэхжүүлэх, малын чанарыг сайжруулах.

2.15. Нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутагт зохион байгууллагдаж буй олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцож тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж хэвшсэн байна.

2.16. Хамран сургах тойргийн Ерөнхий боловсролын сургуульд (1-9 дүгээр анги), сургуулийн өмнөх боловсролд (5 настай хүүхдийг заавал) хүүхдээ бүрэн хамруулдаг байх.

2.17. "Сүү" хөтөлбөрийн хүрээнд ЕБС, СӨБ байгууллагад дэмжлэг үзүүлсэн байх.

2.18. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, товлотт вакцинд хамрагдсан байх.

2.19. Улаан загалмайн нийгэмлэгийн гишүүнтэй байх. /онцгой гишүүн байх/

2.20. Угийн бичиг, зураглал хөтөлдөг байх.

2.21. Амьдралын түвшин доогуур орлоготой малчин өрхийг 50-иас доошгүй малаар малжуулан амьдралын түвшинг дээшлүүлсэн байх.

2.22. Ердийн унаа, хөсөг хэрэглэдэг байхын зэрэгцээ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулж амьдрал ахуйдаа хэрэглэж хэвшсэн байх (эсгий хийх, сур элдэх, арьс нэхий элдэх, хөхүүр сав хэрэглэх), үзэсгэлэн худалдаанд оролцсон байх.

2.23. Айл өрх ахуйн хэрэглээнд хүнсний зориулалтын сав суулгыг хэрэглэж хэвшсэн байх.

2.24. Жил бүр хуулийн дагуу ногдсон албан татвар, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байх.

2.25. Мал аж ахуйн салбарт 10-аас дээш жил ажилласан байх.

2.26. Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан, БИНХ-аар тус бүр хэлэлцсэн, 1-2 малчны материалыг бэлтгэн оруулах.

2.29. “Сумын аварга малчин”-ы болзлыг хангасанаас хойш 3-аас доошгүй жил хүртэлх хугацаанд “Аймгийн аварга малчин”-д тодорхойлох.

Гурав. Хугацаа

3.1. Тухайн оны 12 дугаар сарын 25-нд ХААТМ материалыг хүлээн авах.

3.2. Багуудаас хүлээн авсан Сумын Засаг даргын дэргэдэх удирдлагын баг 01 сарын 10-ыг хүртэл тухайн өрхийн бодит байдалтай газар дээр нь танилцан, ажиллаж хэлэлцэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Бүрдүүлэх материал

4.1. БИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, Багийн Засаг даргын тодорхойлолт

4.2. Журмын заалтуудад холбогдох албан тушаалтнуудын тодохойлолт, нотлох баримт бичиг

4.3. Малчны (нөхөр, эхнэрийн) анкет

4.4. Ажлын үзүүлэлт

4.5. Иргэний үнэмлэхний хуулбар

4.6. Малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр

4.7.Ажил байдлын тодорхойлолт

4.8.Журманд заасан материалуудыг фото зургаар баталгаажуулсан байна.

Тав. Шалгаруулалт

5.1.Журмын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын материалыг хянаж, харьцуулан, баллын системээр дүгнэж, Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрээр шагнаж урамшуулах.

5.2.Сумын аварга малчин шалгаруулах журмын аль нэг үзүүлэлтийг дутуу, нотлох баримтгүй бол шалгаруулалтад оруулахгүй, удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэхгүй.

Зургаа. Шагналын сан

6.1."Сумын аварга малчин" шагналын сан нь нийт 500,000 төгрөгийн үнэ бүхий зүйл "Батламж", тууз, энгэрийн тэмдэг байна. Санхүүг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргана.

6.2.Шагналыг жил бүрийн малчдын зөвлөгөөнөөр гардуулах.

Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

-----o0o-----



СУМЫН АВАРГА СААЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, төллөсөн малаа саалинд бүрэн хамруулж, өрхийн үйлдвэрлэлээр хамгийн их сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байгаа саальчны хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан саальчны ажлын үзүүлэлтийг нь үндэслэн “Сумын аварга саальчин”-аар шалгаруулна.

1.3. “Сумын аварга саальчин”-аар шалгаруулах асуудлыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шалгуур үзүүлэлт хангасан саальчны материалыг Хөдөө аж ахуйн тасаг хүлээн авч, Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлогдоход тавигдах шаардлага

Аймгийн аварга саальчнаар тодорхойлогдож байгаа саальчин дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.1. Хээлтэгчээс бойжуулсан төлийн тоо сумын дунджаас илүү байх.

2.2. Мал сүрэгт эзлэх хээлтэгчийн эзлэх хувь жил бүр өссөн, хээлтэгч бог малд 50, бод малд 40-өөс доошгүй хувь байх.

2.3. Төллөсөн бүх хээлтэгчийг саалинд бүрэн хамруулсан, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх.

2.4. Нэг хээлтэгчээс сааж байгаа сүү нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр, сүү, цагаан идээгээ зах зээлд борлуулсан байх.

2.5. Мал саах, сүүгээ боловсруулах арга ажиллагаанд жил бүр 1-ээс доошгүй саальчныг зааж сурган шавь саальчинтай болсон байх ба Ерөнхий боловсролын сургуультай хамтран “Хөдөлмөр зуслан” үйл ажиллагааг дэмжинэ.

2.6. Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх.

2.7. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний Календарчилсан төлөвлөгөөнд мал сүргээ бүрэн хамруулж, Мал эмнэлгийн үйлчилгээний лавлагааг нэгдсэн системээс татан авч мал эмнэлгийн улсын байцаагчаар баталгаажуулах.

2.8. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг хувиарийн дагуу ашиглах, отор хийх, сэлгэх, өнжөөх, зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх.

2.9. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, гэрийн хашаа, малын хашаа, өвс тэжээлийн хашаа, 00, уст цэгтэй түүнийгээ засч тохижуулдаг байх.

2.10. Говь, цөлийн бүсэд тогтоосон нормын дагуу хонин толгойд шилжүүлсэнээр 5 кг-аар тооцож, хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх.

2.11. Сүүлийн 3 жил өвөлжөө, хаваржааг халдваргүйжүүлэлтэд хамруулсан байх.

2.12. Хоршоо бүлгийн зохион байгуулалтад нэгдэн хамтран ажилладаг байх.

2.13. Нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутагт зохион байгууллагдаж буй олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцож тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж хэвшсэн байна.

2.14. Хамран сургах тойргийн Ерөнхий боловсролын сургуульд (1-9 дүгээр анги), сургуулийн өмнөх боловсролд (5 настай хүүхдийг заавал) хүүхдээ бүрэн хамруулдаг байх.

2.15. Сүү хөтөлбөрт зайлшгүй дэмжлэг үзүүлсэн байх.

2.16. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, товлोलт вакцинд хамрагдсан байх.

2.17. Угийн бичиг, зураглал хөтөлдөг байх.

2.18. Айл өрх ахуйн хэрэглээнд хүнсний зориулалтын сав суулгыг хэрэглэж хэвшсэн байх.

2.19.Жил бүр хуулийн дагуу ногдсон албан татвар, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байх.

2.20.Мал аж ахуйн салбарт 10-аас дээш жил ажилласан байх.

2.22.Баг тус бүрээс 1 малчны материалыг бэлтгэн оруулах.

2.23.“Сумын аварга саальчин”-ы болзлыг хангасанаас хойш 3-аас доошгүй жил хүртэлх хугацаанд “Аймгийн аварга саалчин”-д тодорхойлох.

Гурав. Аварга саальчнаар тодорхойлох, шалгаруулах

3.1.Жил бүр малчдын зөвлөгөөн болохоос өмнө ажлын 14 хоногийн дотор материалыг хүлээн авах.

3.2.Багуудаас хүлээн авсан материалыг ажлын 5 хоногийн дотор Сумын Засаг даргын дэргэдэх удирдлагын баг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.3.Сумын аварга саальчнаар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байх.

3.3.1.Саальчны товч анкет

3.3.2.Ажлын үзүүлэлт

3.3.3.БИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, БИНХ-ын тогтоол, Багийн Засаг даргын тодорхойлолт

3.3.4.Иргэний үнэмлэхний хуулбар

3.3.5.Малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр

3.3.6.Ажил байдлын тодорхойлолт

3.3.7.Журмын заалтуудад холбогдох албан тушаалтнуудын тодохойлолт, нотлох баримт бичиг

3.3.8. Журманд заасан материалуудыг фото зургаар баталгаажуулсан байна.

3.4.Журмын шалгуур үзүүлэлтийг хангасан саальчны материалыг хянаж, харьцуулан, баллын системээр дүгнэж, 3 хүртэлх саальчныг Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрээр шагнаж урамшуулах.

Дөрөв. Шагналын олгох

4.1."Сумын аварга саальчин" тус бүрийг 500,000 төгрөгөөр шагнана. Сумын аварга саальчинд олгох цолны үнэмлэх, тууз, энгэрийн тэмдэг бусад шагналын худалдан авах санхүүг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлнэ.

4.2.Шагналыг жил бүрийн малчдын зөвлөгөөнөөр гардуулах.

Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

-----oOo-----

